НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН ХЯТАД ХЭЛНИЙ БАГШ Х.БАЯРХАНДЫН 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

## 1. ТӨЛӨВШИЛ

1.1 Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал:

2018-2019 оны хичээлийн жилийн 1, 2-р хагасд намар хаварын сургуулийн гаднах талбайгцэвэрлэх олон нийтийн цэвэрлэгээ, сургуулийн багш нарын дундах спорт өдөрлөг, цэнэглэх цаг, бүлэг нэгтгэлийн хурал, багш нарын баярын үйл ажиллагаа , шинэ жилийн арга хэмжээ, нэгбагнэг арга зүй ур чадварын уралдаан , сургуулиас зохион байгуулсан 3 шатлалтмүүдлсургалт, хэлний наадам, хэлний өдөрлөг, 3-р ангийн үсэглэлийн баяр, хятад хэлний 9-12 дугаар ангийн дунд зохион байгуулсан “Хятад хэлний олимпиад” шагналын зохион байгуулалт, анги дэвших төгсөх шалгалтын шалгагч багш, хятад мэргэжилтэнбагш нарын бичиг баримтыг бүрдүүлэх, сургуулиас зохион байгуулсан хуваарьтолон нийтийн үйл ажиллагаанд амжилттай хамрагдсан.

1.2 Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал:

Энэ хичээлийн жилд шинээр хэрэгжүүлсэн хичээлийн 40 минутын дэг, багшийн дэг, завсарлагааны дэг, төлөвшлийн аяны хүрээнд 6е ангид жагсаж орох, тарах, 00 өрөө ашиглах, сургуулийн цайны газарт хэрхэн үйлчлүүлэхийг тайлбарлан өгч, дэгийн хэрэгжилтэнд анхаарсан. Мөн хичээл ордог сурагчдадаа дэгүүдийг амжилттай хэвшүүлэн өөрийн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан. Завсарлагааны гимнасткийг хичээл ордог ангиудад хамтран хийж ангидаа гимнастик хийлгэх сурагчдыг өдөр өдөрөөр томилон гимнастикийг тогтмол хийлгүүлж хэвшүүлсэн. Сургалтын явцад сурагчдын ухаалаг утасыг салааны ахлагч нар хураан авч, хичээл тарахад сурагчдад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулсан. Хичээл орохоос 15 минутын өмнө ангийн хаягийг барьж жагсааж оруулж, хичээл орохоос өмнө хичээлийн бэлтгэлийг хангаж, байраа эзлэн сууж хэвшсэн нь хичээлээс хоцрох, бусдын анхаарлыг сарниулахаас сэргийлж чадсан. /Зураг1/

1.3 Бусадтай харилцах зан чанар:

Сурагчдад хүндлэл харилцааны хичээлийн ангийн ажлын цагаар нээлттэй асуулт хариултын аргаар сайн мууг ярилцаж, сурагчийн дүрмийн харилцаанд мөрдөх үүргүүдийг танилцуулсан. Мөн харилцааны доголдлоос үүдсэн маргаануудыг оролцогч талуудтай хамтран шийдэж, асуудал, маргааныг хүндрүүлэлгүй шийдвэрлэсэн. Ангидаа “Сонсъё” аяныг өрнүүлэн нэг нэгнийгээ сонсох чадварт суралцуулж, хэвшиж эхэлж байна. /Зураг2/. Сургуулийн удирдлага хамт олон, эцэг эхчүүд, багш нар болон сургуулийн

ажилчидтай харилцахдаа харилцааны ямар нэгэн доголдол гаргаагүй.

1.4 Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил дадал хэвшил зан чанарын байдал:

Хятад хэлний хичээлд ирэх сурагчдыг орох гарах үед ангид авчирч, өөрийн анги руу жагсаалаар хүргэж өгч хэвшсэн мөн хятад хэлний танхимд орохдоо гадуур хувцас өмсөхгүй байх, хичээлийн цүнхээ авчрахгүй, идэж уух зүйлстэй ангид оруулдахгүй байх зөвхөн хятад хэлний хичээлийн хэрэглэгдэхүүнийг авчруулахыг хэвшүүлсэн. Хятад багштай хамтран хичээлийг орж, сурагчдын дэгийн хэрэгжилт, төлөвшилд анхаарч ажилласан

1.5 Гараас гарт хөтөлбөрийн хэрэгжилт:

Гараас гарт хөтөлбөрийн хэрэгжилтэнд ангиа өдөр бүр ангид нь оруулж, жагсаан сурагчдыг дэг журмын дагуу бүрэн тараадаг.

1.6 Жижүүр багшийн үнэлгээ:

Жижүүр багшийн үүрэгт ажлыг сар болгон хуваарийн дагуу чанартай, ямар нэгэн зөрчил гаргаагүй, тухай бүрт нь хариуцсан менежэрээр баталгаажуулж байсан.

/Зураг3/

1.7 Хэдэн судалгаа хийсэн , ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал :

6е ангиас энэ хичээлийн жилд зан төлөвийн судалгаа авсан. Үр дүнд нь экстраверт буюу гадагшаа чиглэсэн зан төлөвтэй 35%, интроверт буюу дотошоо зан төлөвтэй 2%, амбиверт буюу хосолсон зан төлөвтэй 64%-ийг тус тус илэрсэн байна. Темпраментийг тодорхойлох хялбаршуулсан сорил авсан. Үр дүнд нь сангвиник 53%, холерик 18%, меланхолик 4%, флегматик 25% тус тус илэрсэн байна. эцэг эхчүүдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Үр дүнд нь Та хүүхдийнхээ сурч буй орчинд сэтгэл хангалуун байж чаддаг уу? Гэсэн асуултанд 37 эцэг эх хангалуун, 17 эцэг эх дундаж, 1 эцэг эх чаддаггүй гэсэн хариултыг тус тус өгөв. Сургалт хүмүүжлийн талаар ямар чиглэлээр сургалт авах хүсэлтэй байна вэ? Гэсэн асуултад хичээл ордог багш нараас нэмэлт давтлага авах, эх оронч, эерэг хандлага төлөвшүүлэх гэж ихэнх эцэг эхчүүд хариулсан байна. Хичээл ордог 6д,6е, 7д ангийн нийт 175 сурагчаас хятад хэлний түвшин тогтоох HSK шалгалтанд оролцсон эсэх, хэдэн дэсийн болзол хангасан эсэх , цаашид хэдэн дэсийн шалгалт өгөх эсэх судалгааг сурагч нэг бүрээр аван үр дүнг гаргасан. Мөн 8в, 9д, 9в, 10д, 10в, 11в, 11д ангиудын нийт 183 сурагчаас хятад хэлний түвшин тогтоох HSK шалгалтанд тэнцсэн дэс, 10, 11 дүгээр ангиудаас нэмэлтээр ямар мэргэжлээр хаана суралцах төлөвлөгөөтэй байгаа талаарх судалгааг авч нэгтгэсэн. / Хавсралт4/

1.8 Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

Ангидаа мүүдл системийг хэрхэн ашиглах талаах англи хэлний багш

н.Хатанцэцэгтэй хамтарч хичээл орсон, 6е ангид “Бичил нэг хаалганы өдөр”-ийг зохион байгуулж эцэг эхийг мэргэжлийн багш нартай холбосон. Сургуулиас зохион байгуулсан “шинэ жил”-ийн зал чимэглэх ажилд эцэг эхтэйгээ хамт оролцсон. Хичээл ордог ангийн “Нээлттэй хаалга”-ын өдөрлөгөөр болон сургалтын явцад сурагчидын хичээл тасрах, хичээлээс хоцрох , хичээл нөхөх, сурлагаар хоцрох тохиолдол гарах бүрт эцэг эхэд мэдэгдэж, утсаар ярих заавар зөвлөмж өгч, биечлэн уулзаж байсан. Ялангуяа 3д анги, 7д анги.

## 2. МЭДЛЭГ ЧАДВАРЫН АХИЦ

2.1 Гарааны болон оношлох үнэлгээ:

2018-2019 оны хичээлийн жилийн эхэнд ордог ангиудын гарааны онооны шалгалтыг бичгээр авч сурагч нэг бүрээр анализ гарган дүгнэлт хийж хариуцсан сургалтын менежерээр баталгаажуулсан.

2.2 Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалт /мүүдл/:

2018-2019 оны хичээлийн жилийн 1,2-р улирлын нэгж хичээлийн боловсруулалтыг хийн хариуцсан сургалтын менежэрээр баталгаажуулсан. 3,4-р улирлын нэгж хичээлийн боловсруулалтыг хийн хариуцсан сургалтын менежэрээр баталгаажуулж мүүдлт системд оруулсан.

2.3 Стандарт хэрэгжилт:

2018-2019 оны хичээлийн жилийн 1-р хагас жилд 3д анги 8-р түвшин 22, 7-р түвшин 12 сурагч.

6д анги 8-р түвшин 16, 7-р түвшин 18, 6-р түвшин 15, 5-р түвшин 12 сурагч.

6е анги 8-р түвшин 15, 7-р түвшин 20, 6-р түвшин 10, 5-р түвшин 11сурагч.

7д анги 8-р түвшин 17, 7-р түвшин 18, 6-р түвшин 18, 5-р түвшин 4, 4-р түвшин 3 сурагч.

2018-2019 оны хичээлийн жилийн 2-р хагас жилд 3д анги 8-р түвшин 20, 7-р түвшин 5, 6-р түвшин 9 сурагч.

6д анги 8-р түвшин 16, 7-р түвшин 20, 6-р түвшин 18, 5-р түвшин 6 сурагч.

6е анги 8-р түвшин 22, 7-р түвшин 19, 6-р түвшин 11, 5-р түвшин 7сурагч.

7д анги 8-р түвшин 12, 7-р түвшин 17, 6-р түвшин 19, 5-р түвшин 8сурагч, нийт 209 сурагчийг тус тус үнэлж дүгнэсэн.

2.4 Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт:

МУБИС-аас зохион байгуулсан хятад хэлний “HSK шалгалтад сурагчийг хэрхэн бэлдэх вэ” сургалтанд хамрагдаж сертификаттай төгссөн /Зураг5/. Мэргэжлийн ур

чадвар, заах арга барилаа сайжруулахын тулд хятад хэлний багш YU FANG, SHI CUI CUI, WEIJING нарын хичээлд сууж тэмдэглэл хөтөлж, туршлага суддлан заар арга зүйгээ хөгжүүлсэн. Бүлгийнхэнтэйгээ хамтран ажиллаж, сургууль хамт олны аливаа ажилд идэвхитэй оролцож байна. “Нэг баг-Нэг арга зүй” уралдаанд багаараа тусгай байр эзэлсэн. /зураг 6/ Манай сургууль дээр хэрэгжиж байгаа Мүүдл сургалтанд амжилттай хамрагдан шалгалтаа өгөн 96,8дүнтэй хамгаалсан /Зураг7/ . Багш өөрөө хөгжихийн тулд HSK 6 дэсд бэлдэж байна.

2.5 Журнал бичилт:

2018-2019 оны хичээлийн жилийн 1-4 улирлын сурагчийн ирц хэсэг, үнэлгээ 1, үнэлгээ 2 сурагчдын дүнг улирал бүрд зааврын дагуу бичин хариуцсан сургалтын менежерээр тамга даруулж баталгаажуулсан.

2.6 Хичээлд ордог сурагчдын хүртээмж:

2018-2019 оны хичээлийн жилд 3д анги 34 сурагч, 6д анги 30 сурагч, 6е анги 59 сурагч, 7д анги 56 сурагч нийт 209 сурагчдад хятад хэлний хичээлийг заасан.

2.7 Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт:

2018-2019 оны хичээлийн жилийн 9 сараас 6 сар хүртэлх багшийн хөгжлийн дэвтэрийг

бичин хариуцсан сургалтын менежерээр тамга даруулж баталгаажуулсан.

2.8 Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил:

Хичээлээс хоцорсон сурагчдын эцэг эхтэй утсаар ярих , АУБ нартай уулзан хэлэх,

2.9 Нэмэлтээр давтлага өгөх зэрэг ажлыг хийж хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн.

2.10 2.10 Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал:

Сангийн сурагчдаас дээрэлхэлтийн судалгаа авч дээрэлхэлтэд өртсөн болон ангид дээрэлхэлт үйлддэг сурагчидтай ганцаарчлан уулзан ярилцаж, асуух заавар зөвлөмж өгөх, эцэг эхэд уулзалтын мэдээллийг дамжуулах цэцэг эхийн зүгээс хэрхэн хамтарч ажиллах зөвлөмж, “Сонсъё” аян зэрэг төлөвшлийн ажлыг зохион байгуулсанаар ангийн уур амьсгалд эерэг үр дүнд хүрсэн гэж үзэж байна. Мөн Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэсэгтэй хамтарч “1 хором” аяныг танилцуулан тэвчих нь эргээд аюулт, эрсдэлт байдлаас өөрийгөө хамгаалах 1 хэлбэр болохыг таниулах хичээлийг орсон. Ангидаа “Тэргүүний сурагчдын” самбарыг ажиллуулан уралдаан тэмцээнд амжилттай оролцсон сурагчдаа урамшуулж, бусад сурагчдад тэмүүллийг бий болж байна.

**3. АВЬЯАСЫГ НЭЭН ХӨГЖҮҮЛСЭН БАЙДАЛ**

3.1 Сонирхлын судалгаа:

Хичээл ордог 6д , 6е, 7д ангиудаас хятад хэлний түвшин тогтоох HSK шалгалтанд тэнцсэн эсэх сорил судалгааг авсан.

3.2 Дугуйлан секцед хамрагдсан сурагчдыг судалгаа

3.3 Ангийн номын сангийн баяжилт:

208 тоот кабинет хятад хэлний сурах бичиг болон толь бичгүүд хангалттай байдаг.

Багш нар хичээл орох үеэр сурагчдад толь бичиг болон сурах бичгийг өгч хэрэглүүлдэг.

3.4 Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал:

БНХАУ улс тунхагласны баярын үйл ажиллагааг угтаж 6д, 6е, 7д ангийн сурагчдад хятад дуу заан урлагын тоглолтонд бэлтгэсэн. Мөн 3-р ангийн галигүсэрбүтээлхийх, үсэглэлийн баярыг угтан ханзны цэвэр бичиг, өөрийн танилцуулгыг сурагчдаар хийлгэн үсэглэлийн баяраар үзэсгэлэн гаргасан, ази хэлний нэг өдөр, хэлний наадмыг угтан 6д, 6д ангийн сурагчдад хятад зураг зурах арга барилыг заан бүтээл хийлгэсэн.Мөн 7д ангийн сурагчдад бийрэн бичлэг, хайчилбарын талаарх соёлын хичээлийг орж сурагчдаар сурсан зүйлсээр нь бүтээл хийлгэн хэлний өдөр, хэлний наадмаар бүтээлийн үзэсгэлэн гаргаж, 8д ангийн сурагч Нандин-эрдэнэ, 10д ангийн сурагч н. Энхүслэн нарыг сурагчдын бүтээлийг танилцуулахын зэрэгцээ хятад хэлээр хятад соёлыг тайлбарлахад бэлтгэн хүүхдийн ордонд үзэсгэлэн тайлбарлуулсан. /Зураг 8/

3.5 Олимпиад уралдаан тэмцээн:

2018-2019 оны хичээлийн жилийн 12 сард хятад хэлний түвшин тогтоох HSK шалгалтанд нийт 29 сурагчийг 1,2 түвшинд бэлтгэн амжилттай хамрагдуулсан. /зураг 9/

6е ангийг “Авъяаслаг 23-чууд” урлаг наадамд бэлдүүлэн ангиараа 1 дүгээр байр эзэлсэн.

3.6 Багш ажлын байран дээр хөгжсөн байдал:

Ажлын цагаар хятад багш нартайгаа хятадаар ярилцаж ярианы чадвараа дээшлүүлж байгаа , хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах, болон анги удирдах талаар сургалтын менежэрүүдээс, нийгмийн ажилтан заавар зөвлөгөө авах, холбогдолтой номыг уншин, интернет орчноос хайлт хийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. 2018.10.28-30 МУБИС Күнзийн институтээс 5 дахь удаагаа зохион байгуулж буй Хятад хэлний багш нарын HSK шалгалтанд бэлтгэх сургалтанд амжилттай хамрагдсан. Цаашид удирдсан ангидаа төлөвшлийн олон талт ажлыгзохион байгуулах, хятад соёл, түвшин тогтоох шалгалтын агуулгыг сургалтын үйл ажиллагаанд оруулах, хятад хэлний түвшин тогтоох олон улсын HSK 6 дэсийн шалгалтандаа тэнцэн батламжаа авах зорилготой.

## 4. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ

4.1 Цаг ашиглалт : 2018-2019 хичээлийн жилд 7 хоногт 20 цагийн хичээлийг цагийн

Хоцролт, таслалтгүй зааж, сургуулиас зохиогдсон үйл ажиллагаанд алгасалгүй идэвхтэй оролцсон

4.2 Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн : 2018-2019 оны хичээлийн жилд 3-р улиралд зохион байгуулагдсан эцэг эхийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр 6д, 6е ангийн эцэг эхээс сэтгэл ханамжийн судалгааг авсан бөгөөд судалгаанаас эцэг эхчүүд хятад хэлний сургалтын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байдаг боловч нэмэлтээр хоцрогдол арилгах давтлага авах сонирхолтой байдаг нь илэрсэн.

4.3 Хичээлийн цагийн хариуцлага: Хичээлийн 40 минутыг цагийн алдагдалгүйгээр орон сурагчдын мэдлэг чадварын ахиц амжилт болон дадал хэвшил төлөвшил, авьяас хөгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

4.4 Багшийн ёс зүй, хууль эрхзүйн биелэлт : Багшийн ёс зүй болон хууль эрхзүйн дүрэм журмыг цаг тухайд нь судлан өөрийн ажлаа гүйцэтгэж, алдаа гаргахгүй ажиллаа

4.5 Багшийн хичээлийн бэлтгэл :

2018-2019 оны хичээлийн жилийн 1,2-р улирлын нэгж хичээлийн боловсруулалтыг хийнхариуцсан сургалтын менежэрээр баталгаажуулсан. 3,4-р улирлын нэгж хичээлийн боловсруулалтыг хийн хариуцсан сургалтын менежэрээр мөн баталгаажуулж мүүдл системд оруулсан. / Зураг 10/

4.6 Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн : Бага дунд ангийн сурагчид хичээлээс таслах хандлага ажиглагдахгүй байна. сурагчдыг ангиас жагсаан хятад хэлний кабинетэд дагуулан ирж, тарахад жагсаан ангид нь хүргэж өгдөг нь хоцролтоос сэргийлдэг.

4.7 Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал :

Багш үйл ажиллагааны төлөвлөгөө, 7 хоногын цагын төлөвлөлтыг улирал бүрээр хийн хариуцсан менежрээр батлуулан ажилдаа төлөвлөгөөг баримтлан ажиллаж, сургалтын нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөрүүдийг мөн хариуцсан менежрүүдээр батлуулах, мүүдл системд ээлжит хичээлийг дэлгэрэнгүй байрлуулах, бусад баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөж байгаа.

4.8 Сургалтын техник хэрэгсэлтэй ажиллаж байгаа байдал:

Өдөр бүрийн сургалтын үйл ажиллагаандаа 208 тоот кабинетийн зурагт болон дууны техник хэрэгслийг ашиглан хятад хэлний хичээлийн сонирхолтой заахад анхаарч мүүдл систем ашиглан явцын шалгалтыг авсан.

**5. ЭРҮҮЛ МЭНД**

5.1 Мэндлэх хүндлэх , зөв боловсон харилцаа: Өглөө ажилд ирэхдээ бусад бүх

хүмүүстэй зөв сайхан мэндэлдэг. Ангийн болон хичээл заадаг сурагчдадаа бусадтай элдэг боловсон мэндлэх, нэг нэгнээ хүндлэх тал дээр үргэлж хэлж сургадаг.

5.2 Эрүүл мэндийн дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал: Сурагдадаа ширээ сандалаа эмхэлж цэгцлэх, том хог хаягдлыг авах , самбарын алчуур чийглэх зэргийг өдөр бүрийн үйл ажиллагаан дээрээ хэвшүүлэн ажиллаж байна.

5.3 фЭрүүл орчинд байхын ач тусын талаар ойлголт өгч хэвшил болохуйц ажил зохион байгуулж үр дүнд хүрсэн байдал : Сурагчдадаа ширээ сандалаа эмхэлж цэгцлэх, том хог хаягдлыг авах , самбарын алчуур чийглэх, ангийн сурагчдад жижүүрийн хуваарийг гарган жижүүрт үнэлгээ өгч хариуцлагатай жижүүр хийх, их цэвэрлэгээг салаа салаагаар 7 хоногт 1 удаа хийх зэргийг өдөр бүрийн үйл ажиллагаан дээрээ хэвшүүлэх, цэвэр орчинг эрхэмлэн, анги танхимд агаар салхи оруулж, хуваарийн дагуу цэвэрлэгээг хийлгэхийн зэрэгцээ тухайн хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайжруулан тараах материал, цахим хэрэглээг ашиглан хичээл сургалтаа зохион явуулав.

5.4 Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харьцах дадал хэвшилд сургасан

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЦААШИД ТАВИХ ЗОРИЛТ

2018-2019 оны хичээлийн жилийн I болон II хагаст 6е ангийн хариуцаж нийт 209 сурагчид хятад хэлний сургалтын үйл ажиллагааг төлөвлөн амжилттай зохион явуулж сурагчдыг сургалтын явцад төлөвшүүлэх, зөв харилцаа тэр тусмаа бие биенээ хүндэтгэн сонсох харилцааны чадварт сургах, үнэлгээний өөрийн болон бусдыг шударгаар үнэлэх арга барилд сургах мөн сурагчид санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж, илтгэх чадвартай болгоход дэмжин ажилласан бөгөөд эдгээр чадварууд, арга барилыг тухай бүр ажиглан тэмдэглэхийг зорин ажиллаа. Мөн гадаад хэлний хичээлээр эзэмших чадваруудыг жигд хөгжүүлэх бага, дунд ангийн сурагчдын хувьд сонсох ярих чадварыг түлхүү хөгжүүлэхийн тулд дуу шүлэг, жүжигчилсэн тоглолт, илтгэх, ном уншин тэмдэглэл хөтлөх зэрэг сонирхолтой аргуудыг хэрэглэн сургалтын үйл ажиллагааг явуулав. 6е ангийн хувьд “Урлаг наадам”-аар нэгдүгээр байр эзэлсэн нь маш том амжилт байлаа. Мөн 6е ангийн хувьд авъяасыг нээх, хичээлээс гадуурх үзвэр үйлчилгээнд хамрагдах, ангийн төлөвшилийг дэмжих ангийн ажлуудыг орж тус ангитай ажиллаа. Цаашид төлөвлөсөн төлөвшил чадваруудыг хөгжүүлэх ажлаа нарийн тэмдэглэл хөтлөн сурагч бүрийн ахицыг тооцон ажиллах хэрэгтэй байна. Мөн мэдлэг чадварын сорил шалгалтын дүнгийн анализаас харахад сурагчид хэлзүйн дүрэм бөгөөд зохион бичих чадварын алдаа их байгааг анхаарч ажиллах, стандарт хэрэгжилтийн хувьд ангийн сурагчдын түвшнээс

доогуур сурч байгаа сурагчидтай хамтран ажиллаж стандартын хоцрогдолгүй болгоход анхаарч ажиллах болно. Даасан ангийн хувьд сурагчдыг төлөвшүүлэх, анги хамт олны уур амьсгалыг сайжруулах, зөв монгол иргэн болохд зориулсан олон талт ажлуудыг санаачлан хийх зорилготой байна.

**Тайлан бичсэн: Хятад хэлний багш Х. Баярханд**

Тайлангийн зургийн хавсралт:

Зураг1:

**Сургуулиас зохион байгуулсан гимнастик хийх үйл ажиллагааг хэвшил болгосон**



Зураг2: Ангидаа “Сонсъё” аяныг өрнүүлэн нэг нэгнийгээ сонсох чадварт суралцуулж, хэвшиж эхэлж байна.



Зураг3: Жижүүр багшийн үүрэгт ажлыг сар болгон хуваарийн дагуу чанартай, ямар нэгэнзөрчил гаргаагүй



**ЖИЖҮҮР БАГШИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

2018-2019 оны хичээлийн жил

Хятад хэлний мэргэжлийн

Багш Х. Баярхүү

20....он....сар...өдөр

| д/д | Үйл ажиллагаа | Оноо | |
|---|---|---|---|
| 1 | Жижүүр багш цаг баримтлан жижүүр багшийн тэмдгийг зүүж ажлаа эхлэнэ. 1-р ээлж 7.30-13.30 2-р ээлж 13.30-19.00 | 5 | 5 |
| 3 | Сурагчидтай мэндлэн хүлээж авна | 3 | 3 |
| 4 | Хоцорсон сурагчдыг компьютер дээр бүртгэж мэдээлэх | | |
| 6 | Жижүүр ангийн сурагчдадаа шаардлага тавьж хамтран ажиллана. | 4 | 4 |
| 7 | Сурагчдын ирц авна | 2 | 2 |
| 8 | Зар түгээх, гарын үсэг зуруулах | 2 | 2 |
| 9 | Гадны хүмүүсийг сургууль уруу зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй | 4 | 4 |
| 10 | Хүүхдээ хүргэж, авч, эгч байгаа эцэг эхийг сургууль уруу оруулахгүй | | |
| 11 | Өдрийн оролтыг жагсааж эмх цэгцтэй оруулахыг хариуцан ажиллана | 3 | 3 |
| 12 | Хувцасны өлгүүрийн үйл ажиллагаанд зохицуулалт хийнэ. | 2 | 2 |
| 13 | Хичээл сургалтын үйл ажиллагаанд хяналт тавина | 2 | 2 |
| 14 | Жижүүр багшийн тэмдэглэлийг сайтар хөтлөх /Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын талаарх тэмдэглэл/ | 3 | 3 |
| 15 | Дараагийн жижүүр багшид мэдэгдэх | | |
| | Нийт оноо | 30 | 30 |

Хариуцлагатай жижүүр.......................

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ ХОРИН ГУРАВДУГААР НИЙГМИЙН АЖИЛТАН 91114866 СУРГУУЛЬ ТБАГУУГ



**ЖИЖҮҮР БАГШИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

2018-2019 оны хичээлийн

Хятад хэл мэргэжлийн

Багш Баярцэцэг.

20....он....сар...өдөр

| д/д | Үйл ажиллагаа | Оноо | |
|---|---|---|---|
| 1 | Жижүүр багш цаг баримтлан жижүүр багшийн тэмдгийг зүүж ажлаа эхлэнэ. 1-р ээлж 7.30-13.30 2-р ээлж 13.30-19.00 | 5 | 5 |
| 3 | Сурагчидтай мэндлэн хүлээж авна | 3 | 3 |
| 4 | Хоцорсон сурагчдыг компьютер дээр бүртгэж мэдээлэх | | |
| 6 | Жижүүр ангийн сурагчдадаа шаардлага тавьж хамтран ажиллана. | 4 | 4 |
| 7 | Сурагчдын ирц авна | 2 | 2 |
| 8 | Зар түгээх, гарын үсэг зуруулах | 2 | |
| 9 | Гадны хүмүүсийг сургууль уруу зөвшөөрөлгүй нэвтрүүлэхгүй | 4 | |
| 10 | Хүүхдээ хүргэж, авч, эгч байгаа эцэг эхийг сургууль уруу оруулахгүй | | |
| 11 | Өдрийн оролтыг жагсааж эмх цэгцтэй оруулахыг хариуцан ажиллана | 3 | |
| 12 | Хувцасны өлгүүрийн үйл ажиллагаанд зохицуулалт хийнэ. | 2 | |
| 13 | Хичээл сургалтын үйл ажиллагаанд хяналт тавина | 2 | |
| 14 | Жижүүр багшийн тэмдэглэлийг сайтар хөтлөх /Хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын талаарх тэмдэглэл/ | 3 | |
| 15 | Дараагийн жижүүр багшид мэдэгдэх | | |
| | Нийт оноо | 30 | |

Хариуцлагатай жижүүр.......................

Зураг4: 8в, 9д, 9в, 10д, 10в, 11в, 11д ангиудын нийт 183 сурагчаас хятад хэлний түвшин тогтоох HSK шалгалтанд тэнцсэн дэс, 10, 11 дүгээр ангиудаас нэмэлтээр ямар мэргэжлээр хаана суралцах төлөвлөгөөтэй байгаа талаарх судалгааг авч нэгтгэсэн.

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР СУРГУУЛИЙН 11В АНГИЙН СУРАГЧДЫН МЭРГЭЖИЛ СОНГОЛТ БОЛОН ГАДААД ДОТООДЫН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГАА**

2019он

| № | Нэрс | Суралцах чиглэл, мэргэжил | Суралцахыг хүсэж буй улс | Хэлний түвшин /хэдэн онд хамгаалсан/ | Холбогдох дугаар | Тэтгэлэгт эхний шатанд тэнцсэн сурагчид |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Н. Алтанзул | эдийн засаг | Хятад, Тайвань, Австрали | HSK5, 2019 | 88842396 | |
| 2 | У. Анарцэцэг | сэтгэл зүй | АНУ, Солонгос, Япон | HSK3, 2018 | 80145166 | |
| 3 | Б. Анар | сэтгэл зүй | АНУ, Хятад, ~~Норвеги~~ | HSK4, 2018 | 99188549. | |
| 4 | С. Анужин | олон улсын менежмент | Хятад | HSK4, 2018 | 95002024 | |
| 5 | Э. Ариунзаяа | анаг | Норвеги | ~~HSK1~~, байхгүй | 80192998 | |
| 6 | Б. Батчимэг | санхүүгийн аудитор | Хятад, АНУ. | HSK4, 2019 | 99612638 | |
| 7 | Ц. Баярмагнай | | | | | |
| 8 | Х. Гэгээнцэцэг | анаг, эм зүйч, | Хятад | HSK4, 2019 | 80174808 | |
| 9 | Ц. Даваасүрэн | анаг | Англи, Япон | HSK3, 2014 | 99190127 | |
| 10 | Б. Даваадорж | | | | | |
| 11 | Б. Дэлгэрцэцэг | цагдаа | Англи, | HSK3, 2016 | 99246509 | |
| 12 | Ц. Дэлгэрмаа | хэвлэл мэдээлэл эрх зүй | Монгол, АНУ | HSK4, 2015 | 99869011 | |
| 13 | Н. Дэлгэрзул | сэтгэл зүй | Европ | HSK3. 2017 | 89511582 | |
| 14 | [illegible] | хууль | Солонгос | HSK5, 2016 | 91199775 | |

Зураг5: 2018.10.28-30 МУБИС Күнзийн институтээс 5 дахь удаагаа зохион байгуулж буй Хятад хэлний багш нарын HSK шалгалтанд бэлтгэх сургалтанд амжилттай хамрагдсан.



Зураг6: “Нэг баг-Нэг арга зүй” уралдаанд багаараа тусгай байр эзэлсэн.



Зураг7: Манай сургууль дээр хэрэгжиж байгаа Мүүдл сургалтанд амжилттай хамрагдан шалгалтаа өгөн 96,8дүнтэй хамгаалсан


23 ДУГААР СУРГУУЛЬ

moodle

CERTIFICATE

МЭРГЭЖЛИЙН БАГШ Х. Баярханд Д

ДЭЛХИЙН БОЛОВСРОЛЫН ЧИГ ХАНДЛАГА МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ, КОНТЕНТ БҮТЭЭХ "MOODLE " СУРГАЛТАНД ХАМРАГДАЖ 1 КРЕДИТ ХАНГАСАН ТУЛ БАТЛАМЖЛАВ.

ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА:

- "MOODLE " СУРГАЛТ АРГА ЗҮЙ - 10 ЦАГ
- "MOODLE " ДАДЛАГА АЖИЛ - 12 ЦАГ
- "MOODLE " ШАЛГАЛТ - 2 ЦАГ - 96,8%

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
23 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРГАА

УЛААНБААТАР ХОТ
2019-04-03

Зураг 8: Мөн 3-р ангийн галигүүдээр бүтээл хийх, үсэглэлийн баярыг угтан ханзны цэвэр бичиг, өөрийн танилцуулгыг сурагчдаар хийлгэн үсэглэлийн баяраар үзэсгэлэн гаргасан, ази хэлний нэг өдөр, хэлний наадмыг угтан 6д, 6д ангийн сурагчдад хятад зураг зурах арга барилыг заан бүтээл хийлгэсэн.Мөн 7д ангийн сурагчдад бийрэн бичлэг, хайчилбарын талаарх соёлын хичээлийг орж сурагчдаар сурсан зүйлсээр нь бүтээл хийлгэн хэлний өдөр, хэлний наадмаар бүтээлийн үзэсгэлэн гаргасан



Зураг 9:

**Хятад хэлний багш Х. Баярхандын 2018-12-02-ны HSK 2 дэсийн бэлтгэсэн сурагчдын гаргасан үр дүн**

| № | Овог нэр | Анги | Авах оноо | Авсан оноо | | Нийт | ТЭНЦСЭН ЭСЭХ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сонсгол | Уншлага | | |
| 1 | А. ГАНДОЛГОР | 6д | 200 | 69 | 70 | 139 | Тэнцсэн |
| 2 | Б. БАТЦЭРЭН | 6д | 200 | 97 | 98 | 195 | Тэнцсэн |
| 3 | Ц. ХҮСЛЭЭ | 6д | 200 | 97 | 78 | 175 | Тэнцсэн |
| 4 | Ц.ХҮСЛЭН | 6д | 200 | 89 | 98 | 187 | Тэнцсэн |
| 5 | Ш. МАРАЛМАА | 6д | 200 | 86 | 54 | 140 | Тэнцсэн |
| 6 | М. ГАРДИ | 6д | 200 | 80 | 50 | 130 | Тэнцсэн |
| 7 | М. ХАНГАЛ | 6е | 200 | 74 | 82 | 156 | Тэнцсэн |
| 8 | Б. ЭНЭРЭЛ | 6е | 200 | 97 | 62 | 159 | Тэнцсэн |
| 9 | Б. АМИН-ЭРДЭНЭ | 6е | 200 | 97 | 78 | 175 | Тэнцсэн |
| 10 | О.БАЯРТСАЙХАН | 6е | 200 | 91 | 54 | 145 | Тэнцсэн |
| 11 | А.СОЁЛОО | 6е | 200 | 94 | 86 | 180 | Тэнцсэн |
| 12 | Л.СҮЛД | 6е | 200 | 86 | 58 | 144 | Тэнцсэн |
| 13 | Ц.БААТАРСЭЦЭН | 6е | 200 | 83 | 74 | 157 | Тэнцсэн |
| 14 | А.ТЭГШЗАЯА | 6е | 200 | 94 | 74 | 168 | Тэнцсэн |
| 15 | М. ЦЭНДДОЛГОР | 6е | 200 | 83 | 54 | 137 | Тэнцсэн |
| 16 | М. ЭРМҮҮН | 6е | 200 | 91 | 66 | 157 | Тэнцсэн |
| 17 | Х.ЭНХДАРЬ | 6е | 200 | 83 | 70 | 153 | Тэнцсэн |
| 18 | У. БИЛГҮҮНТӨГӨЛДӨР | 6е | 200 | 89 | 58 | 147 | Тэнцсэн |
| 19 | Э.АРИУНЗАЯА | 6е | 200 | 97 | 86 | 183 | Тэнцсэн |

**Хятад хэлний багш Х. Баярхандын 2018-12-02-ны HSK 1 дэсийн бэлтгэсэн сурагчдын гаргасан үр дүн**

| № | Овог нэр | Анги | Авах оноо | Авсан оноо | | Нийт | ТЭНЦСЭН ЭСЭХ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Сонсгол | Уншлага | | |
| 1 | А. Сэнгүм | 6е | 200 | 90 | 88 | 178 | Тэнцсэн |
| 2 | Ж. Билгүүн | 6е | 200 | 90 | 83 | 148 | Тэнцсэн |
| 3 | Б.Энх-учрал | 6е | 200 | 85 | 38 | 178 | Тэнцсэн |
| 4 | М. Итгэлтөгс | 6д | 200 | 75 | 73 | 173 | Тэнцсэн |
| | **Нийт авсан оноо** | | | **255** | **282** | **677** | |

Нийт 4 сурагч бэлтгэсэн. Үүнээс тэнцсэн 4 сурагч

Зураг 10: 3,4-р улирлын нэгж хичээлийн боловсруулалтыг хийн хариуцсан сургалтын менежэрээр баталгаажуулж мүүдлт системд оруулсан.






## Уншлага, дүрэм

Edit

1. Хөгийн дагуу уншаарай




## Дасгал ажил

Edit

1. Доорх үгсээс "Өнөөдөр хүйтэн биш" гэсэн өгүүлбэрийг бүтээн дэвтэр дээрээ бичнэ үү.

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ？ | 。 | 不 | 也 | 今 | 冷 | 吗 | 天 | 很 | 明 | 昨 | 热 |

Зөв хариулт нь

今天不冷。

**Зураг 11:** 6е ангийг “Авъяаслаг 23-чууд” урлаг наадамд бэлдүүлэн ангиараа 1 дүгээр байр эзэлсэн.




**Зураг 12:** хэлний наадмаар бүтээлийн үзэсгэлэн гаргаж, 8д ангийн сурагч Нандин-эрдэнэ, 10д ангийн сурагч н. Энхгүслэн нарыг сурагчдын бүтээлийг танилцуулахын зэрэгцээ хятад хэлээр хятад соёлыг тайлбарлахад бэлтгэн хүүхдийн ордонд үзэсгэлэн тайлбарлуулсан


ОЛОН УЛСЫН
ТҮВШИНЧЛЭЛИЙН ШАЛГАЛТ,ҮР ДҮН
ХЭЛНИЙ ӨДӨРЛӨГИЙН

## 2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД ЦЭНЭГЛЭХ ЦАГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ


ЦЭНЭГЛЭХ ЦАГ

Оюунаа цэнэглэцгээе.

Сэдэв: "Багш нарын 7-р их хурлын мэдээлэл" цэнэглэх цагт хүрэлцэн ирсэн танд баярлалаа.

Хугацаа: 2019.04.22

Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори
23 дугаар сургуулийн захиргаа


ЦЭНЭГЛЭХ ЦАГ

Оюунаа цэнэглэцгээе.

Сэдэв: "Авилгагүй ил тод орчин" цэнэглэх цагт хүрэлцэн ирсэн танд баярлалаа.

Хугацаа: 2019.03.25

Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори
23 дугаар сургуулийн захиргаа


ЦЭНЭГЛЭХ ЦАГ

Оюунаа цэнэглэцгээе.

Сэдэв: "Эерэг бол Гоё" аяны хүрээнд "Эерэг энергийг бэлэглэе" цэнэглэх цагт хүрэлцэн ирсэн танд баярлалаа.

Хугацаа: 2018.11.19

Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори
23 дугаар сургуулийн захиргаа


ЦЭНЭГЛЭХ ЦАГ

Оюунаа цэнэглэцгээе.

Сэдэв: "Эрүүл мэнд гоо сайхан" цэнэглэх цагт хүрэлцэн ирсэн танд баярлалаа.

Хугацаа: 2018.12.03

Нийслэлийн Ерөнхий боловсролын Лаборатори
23 дугаар сургуулийн захиргаа







**Тайлан бичсэн: Хятад хэлний багш Х. Баярханд**